



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн ТОГТООЛ

1977 оны 2 дугаар
сарын II-ний өдөр

Дугаар 40

Улаанбаатар
хот

Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны
дэргэдэх улсын арбитрын талаар
авах зарим арга хэмжээний тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Аймаг, хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитрын дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитрийн үүргийг аймаг, хотын шүүхийн даргад хавсран гүйцэтгүүлж, сар бүр 100 төгрөгийн нэмэгдэл цалин олгож байсугай.

3. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитрын ажилтны цалин, захиргаа, аж ахуйн зардлыг аймаг, хотын шүүхийн төсөвт тусган баталж байхыг Сангийн яам /н.МОЛОМ/-д даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Аймаг, хотын арбитрыг байгуулж, түүний дүрмийг батлах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1965 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 218 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ын Сайд нарын
Зөвлөлийн дарга

Ж.БАТМӨНХ

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн
Хэрэг эрхлэх газрын дарга

Б.БАДАРЧ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн
эрхлэгчийг

/М.ЛХАГВАА/

Сайд нарын Зөвлөлийн 1977 оны
40 дүгээр тогтоолоор батлав.

**АЙМАГ, ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДЭРГЭДЭХ УЛСЫН
АРБИТРЫН ДҮРЭМ**

1. Ерөнхий зүйл

1. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитр нь улс, хоршоолол, олон нийтийн байгууллага хоорондын аж ахуйн маргааныг тогтоосон журмын дагуу хянан шийдвэрлэх, социалист хууль ёс, аж ахуйн гэрээний сахилгыг бэхжүүлэх, албан, үйлдвэрийн газар, аж ахуйн байгууллагын хууль ёсны эрх ашгийг хамгаалах төрийн захиргааны байгууллага мөн.

2. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитрын үндсэн зорилго нь харьяа нутаг дэвсгэр дээрээ албан, үйлдвэрийн газар, аж ахуйн байгууллагад нийгмийн үйлдвэрлэлийн үр ашиг, чанарыг дээшлүүлэх, улсын төлөвлөгөө биелүүлэх, аж ахуйн тооцоо, улсын сахилгыг бэхжүүлэх явдалд идэвхтэй нөлөө үзүүлэх, байгууллагын явцуу эрх ашиг, орон нутгийн хандлага гаргах аливаа ирээдүйн эсрэг шийдвэртэй тэмцэх, арбитрын үйл ажиллагаанд социалист хууль ёсыг нэг мөр, нарийн чанд сахин биелүүлэх, аж ахуйн харилцааг боловсронгуй болгоход оршино.

3. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитр нь үйл ажиллагаандаа энэхүү дүрэм, Улсын арбитрын газрын дүрэм болон БНМАУ-ын бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

4. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитрчийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Улсын арбитрын газрын дарга бөгөөд ерөнхий арбитрчийн тушаалаар томилно. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитр нь үйл ажиллагаагаа Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Улсын арбитрын газрын шууд удирдлагын дор аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэмжлэг туслалцаанд түшиглэн явуулна. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитрч эрх хэмжээнийхээ дотор тушаал, тогтоол гаргана.

5. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитр тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

II. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитрын эрх, үүрэг

6. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитр дор дурдсан үүрэгтэй байна:

а/аж ахуйн маргааныг цаг тухайд нь үнэн зөв шийдвэрлэх;

б/албан, үйлдвэрийн газар, аж ахуйн байгууллагад улсын төлөвлөгөөг хугацаанд нь чанартай биелүүлэх, улсын сахилгыг бэхжүүлэхэд чиглүүлэн, аж ахуйн гэрээ байгуулах, бүртгэх, биелүүлэх, дүгнэх ажлыг аргачилсан удирдлагаар хангаж, хяналт тавих;

в/албан, үйлдвэрийн газар, аж ахуйн байгууллагын үйл ажиллагаанд илэрсэн дутагдлыг арилгах талаар арга хэмжээ авах;

г/аж ахуйн хууль тогтоомжийг сурталчлах;

д/арбитрын статистик бүртгэл хөтлөх;

е/ах дүү социалист орны арбитрын туршлагыг ажилдаа нэвтрүүлэх.

7. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитр дор дурдсан эрх эдэлнэ:

а/хууль тогтоомж, төлөвлөгөөт даалгаврыг зөрчил байгуулсан гэрээг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгох, гэрээнд зохих өөрчлөлт оруулах даалгавар өгөх;

б/аж ахуйн гэрээний сахилга батыг зөрчсөн буруутай албан тушаалтанд тогтоосон журмын дагуу торгууль ноогдуулах;

в/маргаан шийдвэрлэхэд шаардагдах баримт материалыг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, маргагч талуудын зохих албан тушаалтныг дуудан ирүүлэх;

г/маргаан шийдвэрлэхэд шаардлагатай байвал мэргэжлийн дүгнэлт гаргуулахаар экспертиз томилох;

д/үүргээ биелүүлээгүй талаас гаргуулах торгуулийн хэмжээг хууль тогтоомжид заасны дагуу багасгах;

е/төлөвлөгөөт даалгавар, аж ахуйн гэрээний үүргээ ноцтой зөрчсөн талд ноогдуулах торгуулийг 50 хүртэл хувиар нэмж, энэ хэсгийг улсын төсвийн орлогод оруулах;

ж/гэрээний үүргээ биелүүлээгүй албан, үйлдвэрийн газар, аж ахуйн байгууллагаас нөгөө тал нь торгууль төлүүлэх тухай нэхэмжлэл гаргаагүй бол уг торгуулийг өөрийн санаачилгаар гаргуулж, улсын төсвийн орлогод буюу эсхүл нөгөө талын орлогод шилжүүлэх;

з/албан, үйлдвэрийн газар, аж ахуйн байгууллагын аж ахуйн үйл ажиллагаанд оршиж байгаа дутагдлыг хариуцах буруутай албан тушаалтанд шаардлагатай гэж үзвэл сахилга батын буюу захиргааны арга хэмжээ авахуулах буюу эсхүл эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр материалыг зохих байгууллагад шилжүүлэх.

III. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны
дэргэдэх улсын арбитраас маргааныг
хянан шийдвэрлэх үндсэн журам

8. Улс, хоршоолол, олон нийтийн байгууллага хоорондын 100 мянга хүртэл төгрөгийн маргааныг хянан шийдвэрлэнэ.

9. Улс, хоршоолол, олон нийтийн байгууллага хоорондын аж ахуйн маргааныг шийдвэрлэхдээ Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Улсын арбитрын газраас баталсан "Арбитрын байгууллагаас аж ахуйн маргааныг хянан шийдвэрлэх заавар"-ыг мөрдлөгө болгоно.

10. Аж ахуйн маргааныг 15 хоногийн дотор, гэрээ байгуулахын өмнөх маргааныг 3 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

II. Дор дурдсан маргааныг хянан шийдвэрлэхгүй:

а/нэг системийн албан, үйлдвэрийн газар, аж ахуйн байгууллага хоорондын маргаан;

б/улсын банкны байгууллага хариуцагч буюу нэхэмжлэгчээр оролцсон маргаан;

в/төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр ноогдуулсан татвар, хураамжтай холбогдсон маргаан;

г/100 төгрөгнөөс доош хэмжээний нэхэмжлэл бүхий маргаан.

12. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитрын шийдвэрийг эс зөвшөөрвөл 10 хоногийн дотор Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Улсын арбитрын газарт давж заалдах эрхтэй.

13. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитрын шийдвэрийг холбогдох албан, үйлдвэрийн газар, аж ахуйн байгууллагын эрх баригчид заавал биелүүлэх үүрэгтэй. Эс биелүүлбэл банкны байгууллага буюу шүүхийн тогтоол гүйцэтгэгч албадан гүйцэтгэнэ.

14. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитр нь аж ахуйн маргааныг хянан шийдвэрлэх явцад албан, үйлдвэрийн газар, аж ахуйн байгууллагын үйл ажиллагаанд илэрсэн дутагдлыг засуулах талаар тэдгээрийн дарга, эрхлэгч буюу түүний дээд шатны байгууллагад мэдэгдэл бичнэ. Мэдэгдэл хүлээн авсан албан тушаалтан уг дутагдлыг арилгах талаар авсан арга хэмжээнийхээ тухай 2 долоо хоногийн дотор бичгээр хариу мэдэгдэнэ.